Өвөг эцэг/эмэг эх	08	Өрхийн тэргүүлэгчийн эмээ, өвөөг хамааруулна.
Ач/зээ	09	Өрхийн тэргүүлэгчийн төрсөн болон өргөмөл, дагавар хүү, охини хүүхдийг хамааруулна.
Бусад/төрөл төрөгсөд	10	Өрхийн тэргүүлэгчийн өөрийн авга, нагац хамаатнууд болон эхнэр/нөхрийн авга, нагац хамаатнууд, тэдгээрийн эхнэр/нөхөр, хүүхэд, ах, эгч, дүү, эмээ, өвөөг тус тус хамааруулна.
Хамааралгүй	11	Өрхийн тэргүүлэгчтэй ураг төрлийн болон гэр бүлийн ямар нэг хамааралгүй, тусдаа өрх үүсгээгүй хүмүүсийг хамааруулна.

## 6 Хөгжлийн бэрхшээл

### Төрөл:

Төрөлхийн	1	Хөгжлийн бэрхшээлийн төрөлд удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн соготой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан тохиолдлыг хэлнэ.
Олдмол	2	Хөгжлийн бэрхшээлийн төрөлд ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн соготой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан тохиолдлыг хэлнэ.

### Хэлбэр:

Харааны	1	Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсаныг ойлгоно.
Ярианы	2	Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “ярих” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсаныг ойлгоно.
Сонсголын	3	Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “сонсох” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсаныг ойлгоно.
Хөдөлгөөний	4	Биений тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар алдагдсан буюу хязгаарлагдсаныг ойлгоно.
Сэтгэцийн	5	Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлөвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлийн үлдцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцоо дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан оюун ухааны бэрхшээлийг сэтгэцийн эмгэг гэж ойлгоно.
Хавсарсан	6	Хүнд нэгээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, согог тохиолдвол хавсарсан хөгжлийн бэрхшээлд хамруулж ойлгоно.
Бусад	7	Хөгжлийн бэрхшээлийн дээр дурдсан хэлбэрээс бусад ямар нэгэн эмгэг болон өвчний улмаас өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх

чадвараа алдсан буюу хязгаарлагдсаныг ойлгоно.

## 7 Хөдөлмөр эрхлэлтийн байдал

### Цалин хөлстэй ажиллагч

Байнгын ажиллагч	1	Ажлын цагийн доод хэмжээгээр ажиллах нь хүлээн зөвшөөрөгдсөн, байнгын буюу тухайн эдийн засгийн нэгжид ажиллах насын дээд хязгаар, тэтгэврт гарах нас зэргээс бусад хөдөлмөр эрхлэлтийг зогсоох тодорхой хугацаа, нөхцөл заагдаагүйгээр хөдөлмөр эрхэлдэг ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч 48 байж болно. Мөн ажилд ороод удаагүй, туршилтын хугацаандаа ажиллаж байгаа боловч цаашид үргэлжлүүлээд байнгын хугацаагаар ажиллуулахаар хүлээгдэж байгаа ажиллагч орно.
Түр ажиллагч	2	Хөдөлмөр эрхлэх хугацаа нь 3 ба түүнээс дээш сараар хязгаарлагдсан буюу тодорхой хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно.
Тохиолдлын ажиллагч	3	Ажлын тогтсон цаггүй, хөдөлмөр эрхлэлт нь 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлагдсан буюу богино хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм.
Дагалдан, мэргэшиж буй дадлагажигч	4	Ажлын тогтсон цаггүй, хөдөлмөр эрхлэлт нь 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлагдсан буюу богино хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм.
Гүйцэтгэх гэрээлэгч	5	Эдийн засгийн өөр нэг нэгжид, эсвэл уг нэгжээр дамжуулаад бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх зорилгоор арилжааны шинжтэй гэрээ (хөдөлмөрийн бус) байгуулан ажиллаж буй ажиллагч юм.
<b>Ажил олгогч</b>		
Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч	6	Ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол “цалин хөлстэй ажиллагч”-аар ажиллуулан, хувийн бизнесийнхээ үйл ажиллагаанд оролцуулж байгаа байгууллагын эзэн бүхий ажиллагч юм.

Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч	7	Ашиг олох зорилгоор аж ахуй нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуй нэгжийг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандaa нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол “цалин хөлстэй ажиллагч”-аар ажиллуулж байгаа ажиллагч юм.
<b>Ажилтан ажиллуулдаггүй</b>		
ААНБ-ын үйл ажиллагаа эрхлэгч	8	Ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандaa нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол “цалин хөлстэй ажиллагч”-аар ажиллуулан, хувийн бизнесийнхээ үйл ажиллагаанд оролцуулж байгаа байгууллагын эзэн бүхий ажиллагч юм.
Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуй эрхлэгч	9	Ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандaa нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол “цалин хөлстэй ажиллагч”-аар ажиллуулж байгаа ажиллагч юм.
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	10	Өрхийн гишүүд, мөн өөр өрхөд амьдарч буй гэр бүлийн холбоотой (эцэг, эх, ах, дүү гэх мэт) хүмүүсийн эрхэлж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажилд, эсвэл тэдгээрийн цалинтай ажил болон гүйцэтгэх гэрээлэгчээр ажиллаж буй ажилд нь тусалж байгаа ажиллагчийг хэлнэ. Тэд эдийн засгийн нэгжийн үйл ажиллагаанд нь нөлөөлөх шийдвэр гаргадаггүй, үүрэг хүлээдэггүй бөгөөд цалин хөлсгүйгээр оролцож, үйл ажиллагаанаас олсон орлогоос өрх дотроо ашиг хүртдэг.

## 8 Хөдөлмөр эрхлээгүй/бизнес эхлээгүй шалтгаан

Сургуульд сурдаг	1	Хөдөлмөрийн насын, хөдөлмөрийн чадвартай их, дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлийн анхан болон дунд шатны сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, 6 сараас дээш хугацаагаар мэргэжлийн сургалтад хамрагдагч, ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй иргэнийг хэлнэ.
Тэтгэвэрт	2	Өндөр насын тэтгэвэрт энгийн болон хөнгөлөлттэй, тусгай нөхцөлөөр гарсан хүмүүсийг хэлнэ.
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	3	Хөдөлмөрийн насын, хөдөлмөрийн чадвараа байнга буюу удаан хугацаагаар бутэн болон хэсэгчлэн алдсан бөгөөд нөхөн сэргээгдэх боломжгүй хөдөлмөрийн насын хүнийг хэлнэ.

Ажил хайгаад залхсан, ажлын байр байхгүй гэж бодож байна	4	Сүүлийн 30 хоногт ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой хүн амаас хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой буюу мэргэжил, туршлага байхгүйгээс тохиорох ажлын байр олж авч чадахгүй байгаагаас эсвэл хэтэрхий залуу, хөгшин байна гэсэн шалтгаанаар ажил олгогчдын шаардлагад нийцэхгүй байгаагаас ажлын байр хайж олох найдвараа алдан, ажил хайгаагүй байгаа хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ.
Ур чадварт тохирохгүй, туршлага байхгүй	5	Ажил хийх боломжтой хүн амаас хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой буюу мэргэжил, туршлага байхгүйгээс тохиорох ажлын байр олж авч чадахгүй байгаа хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ.
Гэрийн ажилтай	6	Хүүхэд, өндөр настан, өвчтөн асардаг, гэр бүлийн хүний ажлын онцлогоос шалтгаалан хөдөлмөр эрхлээгүй зэрэг тухайн хугацаанд үндсэн үйл ажиллагаа нь эдийн засгийн бус үйл ажиллагаанд тооцогдож буй хөдөлмөрийн насны хүмүүсийг энд хамруулна. Хуулийн дагуу жирэмсний болон хүүхэд төрүүлсний амралт, 2 хүртэлх насны хүүхдээ асардаг захиргааны чөлөөтэй байгаа хүмүүс, цалин хөлстэйгээр гэрийн үйлчлэгч хийж байгаа хүмүүс, биет хэмжээний болон мөнгөн орлого олох зорилгоор гэртээ ажил хийдэг хүмүүс хөдөлмөр эрхэлдэг хүнийг энд хамруулахгүй.
Бусад	7	Дээр дурдсанаас бусад өөр шалтгаанаар ажил хийхгүй байгаа хүмүүсийг энд хамааруулна.

**2. Тооллого, судалгаанд статистикийн зорилгоор өрхийн түвшинд нийтлэгээр ашиглаж байгаа код, ойлголт, тодорхойлолт**

**Хариуцах байгууллага:** Үндэсний Статистикийн Хороо

**Ашиглалт:** Статистикийн мэдээлэл эрхэн гаргахад бүх төрлийн тооллого, судалгаанд ашигладаг.

**Хэрэглэгч:** Үндэсний статистикийн хороо

**Тушаал, шийдвэр:** Үндэсний Статистикийн Хорооны даргын 2019 оны А/151 дүгээр тушаалаар баталсан Хүн ам, орон сууцны тооллогын асуулга, түүнийг нөхөх заавар

д/д	Өрхийн код	Код	Ойлголт, тодорхойлолт
1	Өрхийн сууцны төрөл	Гэр	10 Монголын ард түмний уламжлалт сууц болох бүх төрлийн гэр, цаатны урцыг ойлгоно.

Байшин	20	Байшин гэж нэг болон олон өрөөтэй, дээвэртэй, гадуураа ханатай, сууриас дээвэр хүртэл ханаар хуваагдсан талбай бүхий орон байрыг хэлнэ. Байшинд орон сууцны байшин, бие даасан тохилог сууц (хаус), сууцны тусдаа байшин (гэр хорооллын хашаанд барьсан тоосгон, шавар болон модон ханатай сууцны байшин), нийтийн болон нийтийн зориулалтын бусад байр орно.
Орон сууцны байшин	21	Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, тоолох үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрд зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна. Орон сууцны байшин нь бүх төрлийн дэд бүтцээр хангагдсан, дараах нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байна. Үүнд: (а) Цахилгаан, дулааны шугам сүлжээ болон усан хангамжийн сүлжээтэй; (б) Сууцны дотор бие засах газартай; (в) Сууцны дотор байрлуулсан онгоц, шүршүүртэй; (г) Зориулалтын гал тогоо болон хоол хийх талбайтай байна.
Бие даасан тохилог сууц	22	Нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан, агааржуулалтын систем, ус хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай (ус татдаг) байна. Өрөө тасалгаа нь өөр айлын сууцны өрөө, тасалгааны дээр байрлаагүй, орц, туслах өрөө тасалгаа, дээврийн хөндий, зоорины давхар, шугам сүлжээний хонгил зэрэг нь нийтийн бус зориулалттай сууцыг үүнд хамруулна. Сууцны өрөө /унтлагын ба зочны/, гал тогоо, ариун цэврийн буюу шүршүүрийн өрөө, бие засах өрөө, агуулах, ханын шүүгээтэй мөн мансардтай болон мансардгүй байж болно

<i>Сууцны тусдаа байшин</i>	23 Нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан, агааржуулалтын систем, ус хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай (ус татдаг) байна. Өрөө тасалгаа нь өөр айлын сууцны өрөө, тасалгааны дээр байрлаагүй, орц, туслах өрөө тасалгаа, дээврийн хөндий, зоорины давхар, шугам сүлжээний хонгил зэрэг нь нийтийн бус зориулалттай сууцыг үүнд хамруулна. Сууцны өрөө /унтлагын ба зочны/, гал тогоо, ариун цэврийн буюу шүршүүрийн өрөө, бие засах өрөө, агуулах, ханын шүүгээтэй мөн мансардтай болон мансардгүй байж болно
<i>Оюутан, сурагчдын нийтийн байр</i>	24 Нийтийн байр нь ихэвчлэн нийтийн гал тогоо, бие засах газар, халуун усны шүршүүр, уулзалтын танхимтай байдаг. Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид, бүх шатны сургуулийн оюутан, сурагчдын дотуур байр, түүнтэй адилтгах бусад нийтийн байрыг хэлнэ
<i>Ажиллагчдын нийтийн байр</i>	25 Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид хамтран буюу ганц нэгзээрээ суухад зориулагдсан нийтийн байрыг хэлнэ.
<i>Нийтийн зориулалтын бусад байр</i>	26 Нийтийн байр нь ихэвчлэн нийтийн гал тогоо, бие засах газар, халуун усны шүршүүр, уулзалтын танхимтай байдаг. Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид, бүх шатны сургуулийн оюутан, сурагчдын дотуур байр, түүнтэй адилтгах бусад нийтийн байрыг хэлнэ
<i>Зориулалтын бус сууц</i>	30 Анхнаасаа хүн амьдрах зориулалтаар баригдуй эсвэл хүн амьдрахад зориулан өөрчлөн засаж тохижуулсан, гэхдээ тоолох үед хүн амьдарч байгаа сууц багтана. Энэ нь сургууль, үйлдвэр, албан газар, байгууллагын хэсэг буюу өрөө тасалгаанд (зориулалтаараа аж ахуйн нэгж, байгууллага байрлахад зориулагдсан) өрх айл, хүн ам амьдарч байвал зориулалтын бус сууц гэж үзнэ. Жишээлбэл, вагончик,ambaар, пин, агуулах, дэлгүүр, мухлаг зэрэгт өрх айл, хүн амьдарч байгаа бол зориулалтын бус сууц гэж үзнэ
<i>Бусад сууц</i>	40 Хүн амьдарч байгаа, байнгын бус, түр орогнох, хүн амьдрахад тохиромжгүй байр, талбайг бусад төрөлд хамааруулна. Эдгээрт байшигийн дээвэр, хонгил, орц, дулааны шугам сүлжээний худаг (траншей), ой мод, уул хад, агуй зэрэг орно.

## 2 Өрхийн сууцны эзэмшлийн төрөл

Өөрийн эзэмшлийн	1	Сууцаа хувьчилж авсан болон худалдаж авсан, 73 өөрөө барьсан хувийн өмчийн сууцыг өөрийн эзэмшлийн сууцанд хамруулна.
Бусдын сууцанд түрээстэй суудаг	2	Төрийн болон хувийн аж ахуйн нэгж, байгууллагын эсвэл бусдын хувийн өмчийн сууцыг түрээслэн амьдарч байгаа өрх, хүн амын сууцыг түрээсийн сууц гэж ойлгоно. Сууц ашиглалттай холбоотой төлж буй зардлыг түрээс гэж үзэхгүй
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	3	Төрийн болон хувийн аж ахуйн нэгж байгууллагын эсвэл бусдын хувийн өмчийн сууцанд түрээсийн хэлс төлөхгүйгээр амьдарч байгаа өрх, хүн амын сууцыг бусдын сууцанд түрээсгүй суудаг гэж үзнэ.
Бусад	4	Дээрхээс бусад тохиолдолд сууцны эзэмшлийг бусад гэсэнд хамааруулна
<b>3 Өрхийн усан хангамжийн төрөл</b>		
Төвлөрсөн системд холбогдсон	1	Улсын болон орон нутгийн дулаан, ус хангамж хариуцсан аж ахуйн нэгж, байгууллагаас төвлөрсөн байдлаар ус түгээж байгаа системийг ойлгоно.
Бие даасан системд холбогдсон	2	Улсын болон орон нутгийн дулаан, ус хангамж хариуцсан аж ахуйн нэгж, байгууллагаас хамааралгүйгээр тухайн сууцны хэрэгцээг хангах зорилгоор суурилуулан бие даасан байдлаар ус түгээж байгаа системийг ойлгоно. Тухайлбал, сууцны тусдаа байшинд ихэвчлэн тохиолддог ус халаах бойлер, зөвхөн өрхийн хэрэгцээг хангахад зориулагдсан бага оврын ус түгээх систем гэх мэтийг ойлгоно.

#### 4 Өрхийн ундны усны эх үүсвэр /ихэвчлэн хэрэглэдэг/

Хамгаалагдсан гүний худаг	1	Газрын гүний усны нөөцөд хүрэхийн тулд гүнзгий өрөмдөж гаргасан худгийг ойлгоно. Гүний худгийг хийхдээ жижиг голчтой нүхний хажуу талын хөрс нурахаас болон гадаргын урсац нэвчихээс хамгаалж дотор нь суултын яндан суулгасан байдаг. Хамгаалалт нь бүрэн бүтэн бол хамгаалагдсан гэж үзнэ. Гүний худгаас усыг салхи, цахилгаан эрчим хүч, дизель түлш, нарны эрчим хүчний төхөөрөмж, эсвэл гар шахуургын тусламжтайгаар шахуургадан гаргадаг. Гүний худгийн нийтийн ус түгээх байрыг энд мөн хамруулна.
Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон нийтийн ус түгээх байр	2	Хот, суурин газрын гэр хорооллын төвлөрсөн усан хангамжийн системд холбогдсон ус түгээх байрыг хамруулна.
Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй нийтийн ус түгээх байр	3	Хот, суурин газрын гэр хорооллын төвлөрсөн усан хангамжийн системд холбогдоогүй нийтийн ус түгээх байрыг хамруулна.
Хамгаалагдсан гар худаг	4	Гадаргын урсац худагт орохоос сэргийлж өндөрлөсөн, бетон бүүрэг, мал амьтан, хог унахаас хамгаалсан ам таглаа бүхий худаг.
Хамгаалагдсан булаг, шанд	5	Булгийн эх ундарга нь тусгай хамгаалалтад байдаг, засаж тохижуулан хашиж хамгаалсан, гадаргын урсац орохоос хамгаалж, тоосого болон бетон хийцээр битүүлсэн ус авах зориулалтын хоолойтой булаг, шандыг хамруулна.
Хамгаалагдаагүй гүний худаг	6	Газрын гүний усны нөөцөд хүрэхийн тулд гүнзгий өрөмдөж гаргасан худгийг ойлгоно. Гүний худгийг хийхдээ жижиг голчтой нүхний хажуу талын хөрс нурахаас болон гадаргын урсац нэвчихээс хамгаалж дотор нь суултын яндан суулгасан байдаг. Хамгаалалт нь эвдэрч гэмтсэн тохиолдолд хамгаалагдаагүй гэж үзнэ. Гүний худгаас усыг салхи, цахилгаан эрчим хүч, дизель түлш, нарны эрчим хүчний төхөөрөмж, эсвэл гар шахуургын тусламжтайгаар шахуургадан гаргадаг. Гүний худгийн нийтийн ус түгээх байрыг энд мөн хамруулна.
Хамгаалагдаагүй гар худаг	7	Худагт гадаргын урсац орохоос хамгаалаагүй, мал амьтан хог унахаас хамгаалах ам таглаа муутай гар худгийг ойлгоно.
Хамгаалагдаагүй булаг, шанд	8	Гадаргын урсац болон мал, амьтан орохоос хамгаалаагүй ил задгай буюу засаж тохижуулсан хаалт, хашлагагүй 65 булаг, шандыг хамруулна
Зөөврийн усны үйлчилгээ	9	Эрх бүхий байгууллага, аж ахуй нэгж ус зөөх зориулалтын тээврийн хэрэгслээр тээж борлуулах үйлчилгээг хэлнэ.

Ердийн хөсгөөрх зөөврийн ус	10	Ус зөөврийн зориулалтын авто тээврээс бусад төрлийн ус зөөх хөсөг. Энэ нь усыг үхэр, морь, тэмээн тэрэг болон бусад төрлийн хэрэгслээр зөөврөлөн түгээх үйлчилгээг гүйцэтгэхийг хэлнэ.
Савласан ус	11	Аж ахуйн нэгж, үүд тусгай хяналт, зөвшөөрөл авч, стандартад нийцүүлэн ундны зориулалтаар цэвэршүүлэн савласан, зөвхөн хувийн ариун цэвэр болон ундны зориулалтаар бэлтгэгдсэн усыг хэлнэ.
Хурын ус	12	Бороо, цасны усыг дээвэр ба газрын гадаргуугаас цуглувулж, нөөцлүүрт хадгалсан усыг ойлгоно.
Усны ил эх үүсвэр (гол, мөрөн, нуур, тойром, цөөрөм)	13	Гол, мөрөн, нуур, тойром, цөөрөм, голын салаа, татуурга болон усалгааны сувгаас шууд авсан усыг ойлгоно.
Бусад	14	Дээрхээс өөр ундны эх үүсвэр ашигладаг бол энэ хариултыг сонгоно.

#### 5 Өрхийн цахилгааны эх үүсвэр

Төвлөрсөн систем	1	Хот, суурины ихэнх хэрэглэгчдийг нэгдсэн сүлжээний нэг буюу хэд хэдэн эх үүсгүүрээс төвлөрсөн байдлаар дулаанаар хангаж байвал төвлөрсөн дулаан хангамжийн систем гэнэ. Өөрөөр хэлбэл, улсын цахилгааны шугам сүлжээ болон усан станцаас цахилгаанаа авдаг сууцыг төвлөрсөн систем гэж үзнэ. Цахилгаан станцад холбогдсон цахилгааны сүлжээг (дэд станц) төвлөрсөн систем гэж ойлгоно
Дизель станц	2	Тухайн орон нутгийн хувьд бие даасан дизель станцтай холбогдсон цахилгааны сүлжээтэй орон сууцыг хамааруулна. Энд тусгайлан барьсан дизель станцад холбогдсон цахилгааны сүлжээг ойлгоно.
Сэргээгдэх эрчим хүчиний төхөөрөмж	3	Нар салхины эрчим хүчийг хуримтлуулан цахилгаан эрчим хүч болгодог төхөөрөмжийг үүнд хамааруулна.
Бага оврын цахилгаан үүсгүүр	4	Тухайн нэг өрх болон хэсэг өрхийн хэрэгцээг хангах зорилгоор шатах болон бусад материалыаар ажилладаг бага оврын мотор, цахилгаан үүсгүүрийг үүнд хамааруулна

#### 6 Өрхийн халаалтын эх үүсвэр

Төвлөрсөн систем	1	Улсын болон тухайн орон нутгийн хувьд дулааны цахилгаан станц, уурын зуухтай холбогдсон дулааны сүлжээтэй сууцыг төвлөрсөн халаалттай гэж үзнэ
Уурын зуух	2	Тухайн барилга байгууламжийн халаалтыг шийдэх зорилгоор уурын зуухыг байрлуулан халаалтаа шийддэг бол хувийн уурын зуухаар халаалтаа шийддэг гэж үзнэ.

Цахилгаан халаагуур	3	Тухайн өрхийн хэрэгцээг хангах үүднээс цахилгаан эрчим хүчээр ажилладаг халаах төхөөрөмжийг үүнд хамааруулна.
Газрын гүнийн дулаан	4	Газрын гүний дулаан ашиглан халаалтын эх үүсвэрээ шийддэг бол тухайн сууцны халаалтыг газрын гүний дулааны эх үүсвэртэй гэж үзнэ.
Шатдаг хий	5	Шатдаг хийг (Байгалийн хий) ашиглан халаалтын эх үүсвэрээ шийддэг бол тухайн сууцны халаалтыг шатдаг хийн дулааны эх үүсвэртэй гэж үзнэ.
Нам даралтын зуух	6	Нэг болон хэсэг өрхийн хэрэгцээг хангах үүднээс нэгдсэн халаалтын сүлжээнд ашиглаж буй бага оврын зуухыг үүнд оруулна.
Ердийн галлагаа	7	Энгийнээр галлаж, халаадаг зуух, пийшинтэй бол ердийн галлагатай гэнэ.

#### 7 Өрхийн сууцны доторх бие засах газрын төрөл

Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон	1	Хүний ялгадас, бохир ус зэргийг цуглуулан, гадагшуулах, татан зайлцуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам хоолойн системд холбогдсон бие засах газрыг хамруулна. Энэ 69 систем нь бохирыг цуглуулах, шахуургадах, ариутгах, ялгадас бохирыг устгах зориулалттай байгууламжуудаас бурдэнэ.
Соруулдаг бохир усны цооног	2	Жорлон болон гэрээс хол, газар дор байрлуулсан, ус нэвтэрдэггүй ялгадас, бохирыг хуримтлуулах савтай бохирын хоолойгоор холбогдсон бие засах газрыг ойлгоно. Хуримтлагдсан бохирыг зөөж халдвартгуйжүүлэн цэвэрлэнэ.
Битүү тунгаагуур	3	Бохир усан дахь үл уусах хольц болон шим бодисыг агааргүй орчинд бактерийн тусламжтайгаар эрдэсжүүлэн тунгаах замаар бохир уснаас ялгах тунгаагуурыг хэлнэ. Тунасан лагийг үе үе юулж цэвэрлэнэ. /Орчин үеийн технологийн дэвшлийг ашиглан стандартын дагуу хийгдсэн, шаардлага хангасан ариун цэврийн байгууламж/
Бусад	4	Бие засах газар сууцны дотор байрладаг боловч дээрх төрлүүдээс өөр бие засах газартайг ойлгоно.

#### 8 Өрхийн сууцны гаднах бие засах газрын төрөл

Энгийн нүхэн жорлон	1	Газарт ухсан нүхэнд ялгадас хуримтлагддаг бөгөөд гадаргын ус орохоос сэргийлсэн, тавцан суурь нь газраас дээш өндөрлөгдсөн нүхэн жорлонг ойлгоно. Энгийн нүхэн жорлон нь суултууртай, эсвэл суухад зориулагдсан тавцантай байна.
---------------------	---	--

Сайжруулсан нүхэн жорлон	2	Дээвэр дээрээ агааржуулах хоолой, эсвэл яндантай, хоолой болон яндангийн амсрэг ялаа, шавж орохоос хамгаалан тороор тагласан, газар ухаж хавтангаар доторлосон, суудалд тааруулж гаргасан нүхтэй, гадаргын ус орохоос хамгаалж бүх талаас нь хаалт хийсэн жорлонг ойлгоно. Мөн хагас нэвчилттэй жорлон болон нэвчилтгүй жорлонг мөн сайжруулсан нүхэн жорлонд авч үзнэ. (Дотор талыг харанхуй байлгадаг)
Био жорлон	3	Нүүрстөрөгчөөр баялаг материал (хүнсний ногооны хаягдал, сүрэл, өвс, үртэс, үнс) ашиглан хүний өтгөн ялгадсаар үнэргүй, гэм хоргүй бордоо хийх хуурай бие засах газрыг оруулна. Энд зөөж авч явдаг болон суурин зориулалттай аль алиныг хамруулна.
Битүү тунгаагур (Септик)	4	Бохир усан дахь үл уусах хольц болон шим бодисыг агааргүй орчинд бактерийн тусламжтайгаар эрдэсжүүлэн тунгаах замаар бохир уснаас ялгах тунгаагуурыг ойлгоно. Тунасан лагийг үе үе юулж цэвэрлэнэ.
Задгай нүх	5	Тавцан, гишгүүр, суултуургүй, ялгадас хуримтлуулах энгийн ухсан нүхийг хамруулна. (халхавчтай)

## 9 Өрхийн бохир ус зайлцуулалт

Төвлөрсөн систем	1	Улсын болон тухайн орон нутгийн бохир ус зайлцуулалт хариуцсан аж ахуйн нэгж, байгууллага төвлөрсөн байдлаар бохир ус зайлцуулдаг системийг оруулна.
Бие даасан систем	2	Тухайн орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор сууринуулсан, орон нутгийн ус хангамж хариуцсан аж ахуйн нэгж, байгууллагаас хамааралгүйгээр бохир ус зайлцуулах бага хэмжээний системийг оруулна. Тухайлбал, хувийн болон амины орон сууцны зөвхөн өрхийн хэрэгцээг хангахад зориулагдсан бохир ус зайлцуулах, бага оврын систем (бохир, ялгадас саармагжуулах танк) орно.
Цооногт асгадаг	3	Хүчилтгэсэн болон энгийн доторлогоотой, тооцоолсон эзлэхүүнтэй нүхэнд ахуйн хэрэглээнээс гарсан бохир угаадсыг хуримтлуулах, зайлцуулах шаардлага хангасан хийц бүхий байгууламжийг ойлгоно.
Угаадасны нүхэнд асгадаг	4	Бохир усыг цуглуулах, хөрсөнд шингээдэг нүхийг ойлгоно.
Задгай асгадаг	5	Тусгайлан зориулсан бохир ус зайлцуулах цооноггүй, задгай газарт бохир усаа асгадаг болон зөөх, булах гэх мэт гар аргаар бохирлыг зайлцуулдаг тохиолдлууд орно.

## 10 Өрхийн хог хаягдлын зайлцуулалт

Тохижилт үйлчилгээний байгууллагаар	1	Улсын болон тухайн орон нутгийн албан ёсны тохижилт, үйлчилгээний байгууллага эсвэл бусадтай (хог ачигчтай) гэрээ хийж хог хаягдлыг зайлцуулдаг тохиолдлыг хамааруулна.
Зөвшөөрөгдсөн цэгт хаядаг	3	Албан ёсны тохижилт, үйлчилгээний байгууллагын зааварчилгаагаар эсвэл албан зохицуулалтгүйгээр оршин суугчид хогоо нийтийн хогийн газар болон тодорхой төвлөрсөн цэгт зайлцуулдаг тохиолдлыг хамааруулна.
Шатаадаг	4	Хог зайлцуулах тодорхой газаргүй, хогоо хуримтлуулж байгаад шатаадаг тохиолдлыг хамруулна.
Булдаг	5	Хог зайлцуулах тодорхой газаргүй, хогоо хуримтлуулж байгаад газар нүх ухаж булдаг тохиолдлыг хамруулна.
Ил задгай /тогтсон газар байхгүй/	6	Хог зайлцуулах тодорхой газаргүй, хогоо ил 72 задгай хаядаг тохиолдлыг хамруулна.

### 3. Засаг захиргааны нэгжийн код

<b>Хариуцах байгууллага:</b>	Стандартчилал, хэмжил зүйн үндэсний газар
<b>Ашиглалт:</b>	Түүвэр судалгаа, мэдээллийн сангийн хүрээнд мэдээ нэгтгэх, дамжуулахад ашигладаг.
<b>Хэрэглэгч:</b>	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд
<b>Тушаал, шийдвэр:</b>	Стандартчилал, хэмжил зүйн Үндэсний зөвлөлийн 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 25 дугаар тогтоол.

### 4. Улс, орны нутаг дэвсгэрийн ангиалал, код

<b>Хариуцах байгууллага:</b>	Үндэсний Статистикийн Хороо
<b>Ашиглалт:</b>	Албан ёсны болон захиргааны статистик мэдээлэлд улсын нэrsийг давхардалгүй, албан ёсны нэршлээр ашиглах мэн статистик мэдээллийн бааз бүрдүүлэх.
<b>Хэрэглэгч:</b>	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд
<b>Тушаал, шийдвэр:</b>	2019 оны 7-р сарын 10 -ны өдөр Үндэсний Статистикийн Хорооны дарга А/104 дугаар тушаалыг баталсан.

---oo---